



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 481

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэдийн өмчөөс худалдан авсан Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3 дугаар багт байрлах хавсралтад заасан 2 өрөө орон сууцыг төрийн өмчид хүлээн авч, Өмнөговь аймгийн Прокурорын газарт эзэмшүүлж, бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Өмнөговь аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Ганбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах,

2.3.Энэ шийдвэрийг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж бүртгүүлэх, хөрөнгийн үнэлгээг шинэчлэн тогтоосныг мэдэгдэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003479

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны ...¹¹... дүгээр сарын...⁰⁸...өдрийн
...⁴⁸⁷...дугаар тогтоолын хавсралт



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ,
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ**

| д/д | Үндсэн хөрөнгийн байршил нэр | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ /бүртгэх үнэ/ (төгрөг) |
|-----|--|----------------------|-------------|------------|--|
| 1 | Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3 дугаар багт байрлах 12 байрны 3 давхарын 26 тоот 2 өрөө орон сууц | 1982 | м.кв | 45.9 | 65,576,830.00 |
| 2 | Нийт дүн | | | | (жаран таван сая таван зуун далан зургаан мянга найман зуун гуч) |